


# ЦАХИМ ДААТГАЛЫН ХҮСЭЛТИЙН ГАРЫН АВЛАГА

*Илүү хялбар*

*илүү шуурхай*

## АЛХАМ 1. ДААТГАЛЫН ТӨРӨЛ СОНГОХ




Төрийн банкны цахим даатгалын үйлчилгээний цэсд хандаж сонгож буй даатгалын төрлийг зурган дээр дарж нэвтэрнэ

## АЛХАМ 2. ДААТГАЛЫН КОМПАНИ БОЛОН БҮТЭЭГДЭХҮҮНЭЭ СОНГОХ

**Мотоциклийн даатгал - даатгалын эрсдэл /хамгаалалт/**

•Зам тээврийн хөдөлгөөний бүх төрлийн осол;
•Гал түймэр, бүх төрлийн тэсрэлт, дэлбэрэлт /зогсоол, гражид байх үеийн болон бусад үеийн/;
•Байгалийн эрсдэл /зогсоол, гражид байх үеийн болон бусад үеийн газар хөдлөлт, үер, аадар бороо, аянга, мөндөр, хүчит салхи гэх мэт/;
•Биет зүйл унах /зогсоол, гражид байх үеийн болон бусад үеийн/;
•Тээврийн хэрэгсэлд цахилгааны богино холболтын улмаас үүссэн галын эрсдэл;
•Даатгуулагчаас гадна жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээнд нэр нь бичигдсэн этгээд тээврийн хэрэгслийг жолоодох үеийн зам тээврийн осол.
•Эд ангийн болон бүхэлд нь хулгайд алдах;
•Зогсоол болон гражид байх үеийн эрсдэл. Үүнд:
Тээврийн хэрэгслийг оруулах, гаргах, хөдөлгөх, байрлуулах үеийн;
Сантехникийн гэмтлийн улмаас усанд автах, ус чийгийн нөлөөлөл;
Гуравдагч этгээдийн санаатай болон санамсаргүй үйлдлийн улмаас учрах эрсдэл /шил хагарах, цохиулах, мөргүүлэх, мөргөөд зугтах/.

**Тээврийн хэрэгслийн даатгал-D ангилал - даатгалын эрсдэл /хамгаалалт/**

•Зам тээврийн хөдөлгөөний бүх төрлийн осол;
•Гал түймэр, бүх төрлийн тэсрэлт, дэлбэрэлт /зогсоол, гражид байх үеийн болон бусад үеийн/;
•Байгалийн эрсдэл /зогсоол, гражид байх үеийн болон бусад үеийн газар хөдлөлт, үер, аадар бороо, аянга, мөндөр, хүчит салхи гэх мэт/;
•Биет зүйл унах /зогсоол, гражид байх үеийн болон бусад үеийн/;
•Тээврийн хэрэгсэлд цахилгааны богино холболтын улмаас үүссэн галын эрсдэл;
•Даатгуулагчаас гадна жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээнд нэр нь бичигдсэн этгээд тээврийн хэрэгслийг жолоодох үеийн зам тээврийн осол.
•Эд ангийн болон бүхэлд нь хулгайд алдах;
•Зогсоол болон гражид байх үеийн эрсдэл. Үүнд:

Та даатгалын эрсдэл буюу хамгаалалтыг уншиж танилцана уу.

# АЛХАМ 2. ДААТГАЛЫН КОМПАНИ БОЛОН БҮТЭЭГДЭХҮҮНЭЭ СОНГОХ

Та өөрийн сонгож буй даатгалын бүтээгдэхүүн болон даатгалын компани харалдаа хураамжийн хувьтай нүдэн дээр дарна уу...

| Даатгалын бүтээгдэхүүн | "Ард даатгал" ХК | "Бодь даатгал" ХХК | "МИГ даатгал" ХХК | "Монгол даатгал" ХК | "Мөнх даатгал" ХХК | "Номин даатгал" ХХК | "Практикал даатгал" ХХК | "Тэнгэр даатгал" ХХК | "Улаанбаатар хотын даатгал" ХХК |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Мотоциклийн даатгал | 1 | 1 | 1.5 | 0.6 | 1 | 1.5 | 1 | 2.15 | 2 |
| Тээврийн хэрэгслийн даатгал-D ангилал | 1.5 | 1.5 | 1.2 | 1.2 | 1.75 | 1.5 | 1.5 | 3.7 | |
| Тээврийн хэрэгслийн даатгал-B ангилал | 1 | 1.1 | 1.1 | 1.2 | 1 | 1 | 1 | 2 | |
| Тээврийн хэрэгслийн даатгал-C ангилал | 1.2 | 1.2 | 1 | 1.2 | 1.2 | 1.3 | 1.2 | 2 | |
| Цахилгаан тээврийн хэрэгслийн даатгал-B ангилал | 1 | 1 | 3 | 1.2 | 1 | 1.2 | 0.8 | 1.9 | 1.2 |
| Чиргүүлийн даатгал- E ангилал | 1 | 1.2 | 0.8 | 1.3 | 1 | 1.1 | 1.2 | 1.15 | 0.8 |

Төрийн банктай хамтран ажиллаж буй даатгалын компаниас сонголт хийж хураамжийн хувь дээр даран орж бүртгэлийг хийнэ үү.

**Мотоциклийн даатгал - даатгалын эрсдэл /хамгаалалт/**

•Зам тээврийн хөдөлгөөний бүх төрлийн осол;
•Гал түймэр, бүх төрлийн тэсрэлт, дэлбэрэлт /зогсоол, гражид байх үеийн болон бусад үеийн/;
•Байгалийн эрсдэл /зогсоол, гражид байх үеийн болон бусад үеийн газар хөдлөлт, үер, аадар бороо, аянга, мөндөр, хүчит салхи гэх мэт/;
•Биет зүйл унах /зогсоол, гражид байх үеийн болон бусад үеийн/;
•Тээврийн хэрэгсэлд цахилгааны богино холболтын улмаас үүссэн галын эрсдэл;
•Даатгуулагчаас гадна жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээнд нэр нь бичигдсэн этгээд тээврийн хэрэгслийг жолоодох үеийн зам тээврийн осол.
•Эд ангийн болон бүхэлд нь хулгайд алдах;
•Зогсоол болон гражид байх үеийн эрсдэл. Үүнд:
  Тээврийн хэрэгслийг оруулах, гаргах, хөдөлгөх, байрлуулах үеийн;
  Сантехникийн гэмтлийн улмаас усанд автах, ус чийгийн нөлөөлөл;
  Гуравдагч этгээдийн санаатай болон санамсаргүй үйлдлийн улмаас учрах эрсдэл /шил хагарах, цохиулах, мөргүүлэх, мөргөөд зугтах/.

**Тээврийн хэрэгслийн даатгал-D ангилал - даатгалын эрсдэл /хамгаалалт/**

•Зам тээврийн хөдөлгөөний бүх төрлийн осол;
•Гал түймэр, бүх төрлийн тэсрэлт, дэлбэрэлт /зогсоол, гражид байх үеийн болон бусад үеийн/;
•Байгалийн эрсдэл /зогсоол, гражид байх үеийн болон бусад үеийн газар хөдлөлт, үер, аадар бороо, аянга, мөндөр, хүчит салхи гэх мэт/;
•Биет зүйл унах /зогсоол, гражид байх үеийн болон бусад үеийн/;
•Тээврийн хэрэгсэлд цахилгааны богино холболтын улмаас үүссэн галын эрсдэл;

## АЛХАМ 3. БҮРТГҮҮЛЭХ




Даатгалын бүтээгдэхүүний төрлөөс шалтгаалан бөглөх мэдээллүүд өөр өөр байгаа тул сонгосон бүтээгдэхүүний өгөгдлийн дагуу мэдээллээ үнэн, зөв, алдаагүй, бүрэн бөглөж **“Хүсэлт илгээх”** товчийг дарна.
Банк таны хүсэлтийг хүлээж авсан даруй таны бүртгүүлсэн и-мэйл хаягт хариу өгнө.

## АЛХАМ 4. БҮРТГҮҮЛЭХ

- Банкнаас и-мэйлээр ирсэн зааврын дагуу холбогдох баримт бичиг бүрдүүлэн, өөрийн сонгосон нэгж дээр очиж даатгалын хураамж төлөн гэрээг баталгаажуулан авна уу.
- Даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээнд бүртгүүлсэн өдрөөс хойш ажлын 5 өдөр таны мэдээлэл хадгалагдана. Хэрэв заасан хугацаанд ирж амжихгүй бол уг даатгалын бүртгэлийг хүчингүйд тооцно.



## ДААТГАЛЫН МЭДЭЭЛЛИЙГ ӨГӨДЛИЙН ДАГУУ БӨГЛӨХӨД ЗОРИУЛСАН ЗӨВЛӨМЖ.

**1.** Даатгуулагчийн ерөнхий мэдээлэл хэсэгт дараах зааврын дагуу мэдээллийг оруулах.

- ☑ Үл хөдлөх хөрөнгө, хөдлөх хөрөнгө, тээврийн хэрэгслийн даатгалын хувьд тухайн хөрөнгийн гэрчилгээн дээр бичигдсэн өмчлөгч/эзэмшигч/-ийн нэр дээр бүртгэх







- ☑ Гэнэтийн ослын даатгалыг зөвхөн хувь хүн дээр бүртгэнэ. Мөн Хүүхдийн гэнэтийн осол, хурдан морь унаач хүүхдийн гэнэтийн ослын даатгалд даатгуулагчаар асран хамгаалагч эцэг эх бус хүүхдийн мэдээллийг бүртгэх
- ☑ Зээлийн даатгалд Төрийн банкнаас авсан зээлдэгч /хувь хүн байх/-ийн хувьд уг даатгалыг хийх боломжтойг анхаарах.



# ДААТГАЛЫН МЭДЭЭЛЛИЙГ ӨГӨДЛИЙН ДАГУУ БӨГЛӨХӨД ЗОРИУЛСАН ЗӨВЛӨМЖ.

**2.** Зураг оруулах.

☑ Үл хөдлөх хөрөнгө, хөдлөх хөрөнгө, тээврийн хэрэгслийн даатгалын хувьд өгөгдлийн дагуу хөрөнгийн зургийг үнэн зөв оруулах шаардлагатай. Энэ нь даатгалын тохиолдол гарахад таны хөрөнгө даатгагдах үедээ бүрэн бүтэн байсныг нотлох баримт гэдгийг анхаарна уу.

### 1. ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЗУРАГ АВАХ СТАНДАРТ



**1.1** Тээврийн хэрэгслийг бүрэн харагдахаар ард талаас **ДИАГОНАЛЬДАН, УЛСЫН ДУГААРЫГ** харагдахаар зургийг авах,

ЗӨВ Ард талаас **диагональ** байдлаар зураг авснаар зүүн талын **/2 хаалга болон, арын гүпер, улсын дугаар/** бүтнээр харагдаж байна. Зургийн стандартын 1.1-т заасан стандартын дагуу бүрэн бүтэн байсныг НОТЛОЖ байна.

✓ Сэвтэй бол сэвтэй хэсгийг ойртуулж авна.



**1.2** Тээврийн хэрэгслийг бүрэн харагдахаар урд талаас **ДИАГОНАЛЬДАН УЛСЫН ДУГААРЫГ** харагдахаар зургийг авах,

ЗӨВ Урд талаас **диагональ** байдлаар зураг авснаар баруун талын **/2 хаалга болон, урд талын гүпер, улсын дугаар/** бүтнээр харагдаж байна. Зургийн стандартын 1.1-т заасан стандартын дагуу бүрэн бүтэн байсныг НОТЛОЖ байна.

✓ Сэвтэй бол сэвтэй хэсгийг ойртуулж авна.




**1.3** **АРЛЫН ДУГААР**-ын зургийг авах,

ЗӨВ Тухайн тээврийн хэрэгслийн **АРЛЫН ДУГААР**-ыг тодоор татаж авсан байна.

### 2. ЦАХИЛГААН БАРАА, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЗУРАГ АВАХ СТАНДАРТ



**2.1** Цахилгаан бараа, тоног төхөөрөмжийг **БҮТЭН ХАРАГДАХААР** урд талаас зургийг авах

ЗӨВ Уг цахилгаан бараа эгц урдаас тухайн телевизийн **ЛОГО** болон бүрэн бүтэн байдлыг харуулсан СТАНДАРТЫН дагуу зураг байна



**2.2** Цахилгаан бараа, тоног төхөөрөмжийн **МАРК СЕРИЙН ДУГААР** бүхий хэсгийн зургийг авах

ЗӨВ Уг цахилгаан барааны **МАРК СЕРИЙН ДУГААР** бүхий хэсгийг тодорхой харуулсан стандартын дагуу зураг оруулсан зураг байна.

✓ Аль нэг хэсэгтээ эвдэрсэн гэмтсэн сэв байгаа бол түүнийг ойртуулж зургийг авна.

### 3. ТАВИЛГЫН ЗУРАГ АВАХ СТАНДАРТ



**3.1** Тавилгыг **БҮТЭН ХАРАГДАХААР** урдаас нь зургийг авах

ЗӨВ Тухайн тавилгыг БҮТЭН ХАРАГДАХААР урдаас нь зургийг авна гэсэн стандартын дагуу авсан байна.

✓ Аль нэг хэсэгтээ эвдэрсэн гэмтсэн сэв байгаа бол түүнийг ойртуулж зургийг авна.

### 4. МОНГОЛ ГЭРИЙН ЗУРАГ АВАХ СТАНДАРТ



**4.1** Гадна талаас нь **ОЙР ХАВИЙН ОРЧНЫГ НЬ ОРОЛЦУУЛСАН** зургийг авах.

ЗӨВ Монгол гэрийг гадна талаас **ОЙР ХАВИЙН ОРЧНЫГ НЬ ОРОЛЦУУЛСАН** зураг авна гэж заасны дагуу зургийг авсан байна.



**4.2** Дотор талаас нь гэрийн **МОДНЫ ХЭЭ, СИЙЛБЭР ОНЦЛОГИЙГ ХАРУУЛСАН** зургийг авах

ЗӨВ Монгол гэрийн дотор талаас **МОДНЫ ХЭЭ, СИЙЛБЭР ОНЦЛОГИЙГ ХАРУУЛСАН** зураг авах стандартын дагуу зураг авсан байна.

### 5. ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ /Орон сууц, үйлдвэрлэл үйлчилгээний зориулалттай обьект, оффисийн барилга/ ЗУРАГ АВАХ СТАНДАРТ





**5.1** Үл хөдлөх эд хөрөнгийн **ДУГААР, ОРЦ, ХААЛГАНЫ ДУГААРЫГ** оруулж зургийг авах.

ЗӨВ Үл хөдлөх эд хөрөнгийн **ДУГААР, ОРЦ, ХААЛГАНЫ ДУГААРЫГ** оруулж зургийг авах стандартын дагуу тухайн байр, орц, хаалганы дугаар оруулсан зураг авсан байна.





**5.2** Хаалганы дугаар болон үүдний хэсгээс **ӨРӨӨНИЙ ХЭСГИЙГ АЛЬ БОЛОХ БАГТААН** оруулж зургийг авах.

ЗӨВ Үүдний хэсгээс зураг авахдаа **ӨРӨӨНИЙ ХЭСГИЙГ АЛЬ БОЛОХ БАГТААН** оруулж зургийг авна гэсэн стандартын дагуу зурийг дээрх байдлаар авна.

### 6. ХАШАА БАЙШИН, АМИНЫ СУУЦ ЗУРАГ АВАХ СТАНДАРТ



**6.1** Хашааны **ХААЛГАНЫ ДУГААРЫГ** оруулж зургийг авах.

ЗӨВ Даатгуулах хашааны ДУГААР тод, стандартын дагуу зураг оруулсан.



**6.2** Хашааны доторх **ДААТГУУЛАХ БАЙШИНГИЙН** зургийг авах.

ЗӨВ Хашааны доторх **ДААТГУУЛАХ БАЙШИН**-ийн зургийн тод харагдахуйц стандартын дагуу зураг авсан байна.

## ДААТГАЛЫН МЭДЭЭЛЛИЙГ ӨГӨДЛИЙН ДАГУУ БӨГЛӨХӨД ЗОРИУЛСАН ЗӨВЛӨМЖ.

**3**. Даатгалын үнэлгээг оруулахдаа үнэлгээний доор байрлах “Анхааруулга”-ыг уншиж оруулна уу. Үүнд:

- ☑ Үл хөдлөх хөрөнгө, хөдлөх хөрөнгө, тээврийн хэрэгслийн даатгалд тухайн хөрөнгийн өртөг, зах зээлийн үнийг оруулах бөгөөд зах зээлийн үнээс бага болон ихээр оруулсан үед даатгалын тохиолдол учирвал даатгалын компани хохирлыг хувь тэнцүүлэн нөхөн төлбөр олгодгийг анхаарна уу.
- ☑ Зээлийн даатгалд Төрийн банкнаас авсан тухайн зээлийн үлдэгдэл дүнг оруулна.
- ☑ Гэнэтийн осол, эмчилгээний даатгал үнэлгээг
  - Хүүхдийн гэнэтийн ослын даатгалд 1,000,000 төгрөгөөс дээш үнэлнэ,
  - Иргэдийн гэнэтийн ослын даатгалд 2,000,000 төгрөгөөс дээш үнэлнэ.
  - Хурдан морь унаач хүүхдийн гэнэтийн ослын даатгалд 20,000,000 төгрөг байна.




**4.** Банкнаас ирсэн имэйлийн дагуу хувийн хэргийн бүрдлийг бүрдүүлэн сонгосон нэгж дээр очиж даатгалын хураамжийг төлж, даатгалын гэрээг баталгаажуулан авна. Үүнд:

- ☑ Үл хөдлөх хөрөнгийн даатгалын хувийн хэргийн бүрдэл
  - Иргэний үнэмлэх
  - Хөрөнгийн гэрчилгээний хуулбар
- ☑ Хөдлөх хөрөнгийн даатгалын хувийн хэргийн бүрдэл
  - Иргэний үнэмлэх
  - Хөрөнгийн гэрчилгээний хуулбар
- ☑ Авто тээврийн хэрэгслийн даатгалын хувийн хэргийн бүрдэл
  - Иргэний үнэмлэх
  - Тээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбар
- ☑ Гэнэтийн осол эмчилгээний даатгалын хувийн хэргийн бүрдэл
- ☑ Хүүхдийн гэнэтийн ослын даатгалын хувьд:
  - Хүүхдийн гэрчилгээ
  - Гэрээ байгуулсан асран хамгаалагчийн иргэний үнэмлэх
- ☑ Иргэдийн гэнэтийн ослын даатгалын хувьд:
  - Иргэний үнэмлэх
- ☑ Зээлийн даатгалын хувийн хэргийн бүрдэл
  - Иргэний үнэмлэх